

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН 2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2019.11.04

Дархан

1. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Төрийн албаны ерөнхий шалгалтын бүртгэл явагдаж аймгийн хэмжээнд 244 иргэн бүртгэгдсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар аймгийн ИТХ-ын ажлын алба, аймгийн ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын төрийн захиргааны албан хаагчдын нийт 85 албан тушаалын тодорхойлолтыг хэлэлцүүлэн батлах зөвшөөрөл авлаа.

Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн, сум, агентлагийн дарга нарын зөвлөгөөн, Засаг даргын зөвлөлийн хурал, шуурхай хурал хуваарийн дагуу хуралдаж цаг үеийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа. Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн 1 удаа, сум, агентлагийн дарга нарын зөвлөгөөнийг 1 удаа, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа, шуурхай хурал 4 удаа хуралдаж цаг үеийн байдалтай холбоотой 88 асуудлыг хэлэлцэн хуралдаж аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, төрийн болон төсвийн байгууллагын удирдлагуудад чиглэл өгөн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 2019 оны 10 дугаар сард 303 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч, 287 иргэний өргөдөл гомдлыг шийдвэрлэж 16 иргэний өргөдөл гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 94,78 хувьтай байна. Үүнээс хүсэлт 289, санал 1, гомдол 13-ыг тус тус ирүүлсэн байна.

Байгууллагын албан хаагчдаас 57 санал хүсэлтийг ирүүлж шийдвэрлэлт 100 хувьтай. Засгийн газрын 1111 төвөөр 28 иргэний санал гомдлыг хүлээн авч 27 иргэний санал хүсэлтийг шийдвэрлэж 1 өргөдөл гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 96,42 хувьтай байна.

Дархан хотын баярыг угтан 10 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Засаг дарга иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулж 500 гаруй иргэд хөдөлмөрчдийг хүлээн авч уулзан 87 иргэний санал хүсэлтийг нээлттэй микрофон саналын хуудсаар хүлээн авч орон нутгийн удирдлагуудаас иргэдэд хариулт өглөө.

Дархан хотын баярыг 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж төрийн байгууллагууд иргэдийг хамрууллаа.

Дархан хотынхоо хөгжлийн түүхийг бичилцэн, бүтээн байгуулалтад гар бие оролцон салбар салбартаа үнэлэгдсэн эрхмүүдэд төрийн шагнал-4, салбарын шагнал-4, аймгийн шагнал-14-ыг тус тус гардуулан өглөө.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг 3 зорилтын хүрээнд 58 арга хэмжээтэй байхаар төлөвлөлөө.

Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат Испанийн Вант улсын Астуриас мужид албан айлчлал хийж “Арьс ширний цогцолбор”-ын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх 3 том гэрээнд гарын үсэг зурлаа. Цогцолборын барилгын ажил эхлэсэн бөгөөд төлөөлөгчид ирэх 3 дугаар сард Монголд ажиллахаар төлөвлөж байна.

Аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд БНСУ-ын Дэжон хотод Дэлхийн технополисийн холбооны удирдах зөвлөлийн хуралд оролцож Ухаалаг хотын чиглэлээр туршлага судлав.

2. Эдийн засгийн бодлогын хүрээнд

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 09 дүгээр сарын мэдээг боловсруулж, нэгтгэн Сангийн яам,

аймгийн цахим хаяг <http://darkhan.gov.mn>, АЗДТГ-ын төсөв санхүүгийн ил тод байдлын самбарт тус тус байршуулж, төсвийн ил тод байдлыг хангаж ажилласан.

2019 оны 09-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 18,770.7 сая төгрөг төвлөрөхөөс 19,209.2 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 102.3 хувьтай биелэсэн байна.

Мэдээгээр зарлага санхүүжилтийн хувьд орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарлага санхүүжилтэнд 20,197.4 сая төгрөг зарцуулахаас 17,784.5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 27,169.4 сая төгрөг зарцуулахаас 25,772.3 сая төгрөг зарцуулжээ.

Мөн аймгийн хэмжээнд 09 дүгээр сарын байдлаар 59,878.5 мянган төгрөгийн авлагатай, 1,521,690,4 сая төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд үүнээс:

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагууд 1,953.7 сая төгрөгийн авлагатай, 678,273.2 мянган төгрөгийн өглөгтэй. Орон нутгийн төсвийн байгууллага 57,924.7 мянган төгрөгийн авлагатай, 843,417.0 сая төгрөгийн өглөгтэй байна.

Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох 6 хичээлийн шалгалтын бүртгэлийг хийж байна. 31 нягтлан бодогч шалгалтанд бүртгүүлээ.

Татварын орлогын талаар:

2019.10.14-ны өдөр дахин шүүхийн шийдвэр гүйцэтгэлд байгаа нийт 63 татвар төлөгчийн 1,799,2 сая төгрөг бүхий татвар төлөгч бүрийн өрийг хэрхэн барагдуулж байгаа, учирч байгаа хүндрэлүүд, хэрхэн хамтран ажиллах талаар тойрог хариуцсан гүйцэтгэгч нарыг баг хариуцсан байцаагч нартай нэг бүрчлэн тулгалт хийлгүүлэн нэмэлт мэдээлэл цуглуулах, битүүмжлэх, эрэн сурвалжлах ажлуудыг хийж байна.

2019 оны жилийн өссөн дүнгээрхи татварын нэр төрөл бүрээр төлөвлөгөөний хүлээгдэж буй гүйцэтгэлийн гаргаж, санхүү төрийн сангийн хэлтэсд хүргүүлэн, төсөвт байгууллагуудын дутуу санхүүжилттэй 223,2 сая төгрөгийн татварын асуудлыг төсөвт тодотгох эсэх гаргалгааг хайн ажиллаж байна.

Цагдаагийн газраас “Галт зэвсэг-2019” тооллого бүртгэлийг эхлүүлсэнтэй холбогдуулан хэсгийн байцаагч нартай баг хариуцсан байцаагч нар хамтран ажиллаж, бүртгэл, хөдөлгөөн, татварт хамруулалтыг анхаарч, өдөр бүр хуваарь гарган цагдаагийн газрын 201 тоот өрөөнд ээлжлэн сууж бүртгэлийг шинэчлэх, гэрчилгээг хуулбарлах, утас, мэдээллийг өөрчлөх, татвар ногдуулан хураах, ТУАБ-р нэхэмжлэл үүсгэх ажлуудыг хийж байснаа дахин уулзалт хийн хэсгийн байцаагч нарын хамт гэрээр нь очиж бүртгэл, татварт хамруулалтаа хийхээр болон ажиллагааг явуулж байна. ТУНС-д нийт галт зэвсгийн 45 хувийг ногдол үүсгээд байна.

Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ТЕГ-ын даргын 2018 оны 8 сарын 31-ны өдрийн А/142 тоот тушаалаар өгөгдсөн төлөвлөгөөт ажлын хүрээнд Дархан сумын нутаг дэвсгэрт бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн хувь хүн, хуулийн этгээд нь нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд холбогдсон байдал, төлбөрийн баримт олгож байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, хуулийн хэрэгжилтийг хангуулах, ажлын хүрээнд Хос мишээл ХХК, Наран овоон өргөө ХХК, Дэнс дэнс ХХК нарт НӨАТУС-ийн шаардлага хүргүүлж, Хувиараа хөдөлмөр эрхлэгч 23 татвар төлөгч иргэдэд ebarimt.mn-д бизнес эрхлэгчээр хэрхэн баримт хэвлэх, утсаар болон mail-хаягаар баримт илгээх зэрэг үйлдлийг зааж өгч нийт бизнес эрхлэгч 12 иргэнийг НӨАТУС-д холбон баримт хэвлэн зөвлөгөө өгч ажилласан.

Хувь хүний орлогын албан татвар төлөгчөөр 1 гадаадын иргэн, 5 Монгол иргэнийг бүртгэсэн.

- ✓ ӨАТ суутган төлөгчийн тайлангийн ирцийг 100 хувьд хүргэх зорилго тавин тайлан ирүүлээгүй, хоцроосон бүх ААН дээр байцаагч бүр тулж ажилласан.
- ✓ Цалин хөлс болон ААНОАТ-ын тайланг 2018 оноос хойш ирүүлээгүй 528 татвар төлөгчийн тайланг ирүүлэх ажлыг Орлогын тасгийн хариуцсан байцаагч нартай хамтран хийсэн.
- ✓ Эцсийн хэрэглэгчээр буруу шивсэн засварлах хүсэлт ирүүлсэн 2 ААН-ийн хүсэлтийг шийдвэрлэсэн
- ✓ И-баримтын зөвлөгөөг 30 иргэнд өгч ажилласан
- ✓ Нэхэмжлэх болон төлбөрийн баримтаар 35 иргэнд
- ✓ Тайлан илгээх талаарх зөвлөгөөг 7 хуулийн этгээд
- ✓ Лавлагаа тодорхойлолт 1 иргэн, ААН-д олгосон.
- ✓ Шинээр бүртгүүлэх-2
- ✓ Татан буулгах-5
- ✓ Тоон гарын үсэг авах-5
- ✓ Нууц үг солих-3
- ✓ 1800-1288 дугаарын “Дуудлагын төв”-ийн утас нэвтэрсэнтэй холбоотой дуудлагын төвд 45 иргэн, ААНэгжид татварын хуулийн талаарх мэдээллийг өгсөн.
- ✓ НӨАТ суутган төлөгчөөр 5 хуулийн этгээдийг татварын нэгдсэн системд бүртгэсэн 10 сард төлөвлөгөөгөөр 16 татвар төлөгчийн хяналт шалгалтанд хамруулахаас энэ долоо хоногт 5 ААН-ийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж 85140,4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж шийтгэлийн хуудсаар 6780,2 мянган төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги, хүү ногдуулсан.
Татан буугдах хүсэлтийн дагуу 7 ААН-д хяналт шалгалт хийж 2 татвар төлөгчид зөрчилгүйг илтгэн илтгэх хуудас бичигдсэн.
Хөндлөнгийн мэдээллийн баазад 13 татвар төлөгчийн 425752,5 мянган төгрөгийн хөндлөнгийн мэдээллийг бүртгэн ажиллалаа
5 ААН-ийн хөндлөнгийн мэдээлэл ашиглалтын тайланг шивж ажиллалаа
Тайлант оны хяналт шалгалтын өрнөөс 9 ААН-ийн 15684,9 мянган төгрөгийн өрийг барагдуулан ажиллалаа.

Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр:

Дархан-Уул аймгийн Шарын гол, Орхон, Хонгор сумдын орон нутгийн хөгжлийн сан, Хонгор сумын Засаг даргын тамгын газар, Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар, Бизнес инкубатор төвийн санхүүгийн үйл ажиллагааны баримтын шалгалт дуусч захиргааны хувийн хэрэг бүрдүүлж ажиллалаа.

Шалгалтаар илэрсэн зөрчилд төсвийн орлогод төвлөрүүлэхээр нийт 6744,5 мянган төгрөгийн акт тогтоосон.

Дархан сумын Засаг даргын нөөц сан, Улсын бүртгэлийн газар, Авто тээврийн төв, АШУҮИС-ийн Анагаах ухааны салбар сургууль, ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн 2016-2018 оны санхүүгийн үйл ажиллагааны баримтанд хяналт шалгалтын ажлыг явуулж Захиргааны хэргийн хувийн хэргийг бүрдүүлэн асуулга авч байна.

Актын төлбөрийн үлдэгдэлтэй байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нартай холбогдон актын төлбөрийн үлдэгдлийг барагдуулахыг анхаарууллаа.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд актаар тогтоосон төлбөрийн барагдуулалтаар 2019 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 80,2 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.

3.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын захирамж 17, Засаг даргын Тамгын газрын даргын 13 тушаалд виз олгож, ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлэг гаргах шаардлагатай эсэхийг шийдвэрлэлээ.

Хууль, эрх зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар мэдээллийг “Тодруулга” ярилцлага нэвтрүүлэгт хийлээ.

Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж, АТГ-ын khutulbur.iaac.mn сайтад шивж, ТГ-ын даргаар баталгаажууллаа.

Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын Миний монгол цэцэрлэгт хүрээлэнгийн хөдөлгөөнд тоглоомын төвийн үйл ажиллагааг зохицуулах түр журмыг боловсруулах ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, журмын төсөлд гишүүдийн саналыг авч тусгах журмын төслийг хэлэлцүүлж эхний хувилбарыг боловсруулан гаргалаа.

Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийн 2019 оны 16-15 дугаар эмхэтгэлд гарсан Нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан журам, дүрмийг уншиж судлан Хууль, эрх зүйн хэлтсийн гар лавлагаа санд бүртгэж, дотоод товъёог үйлдлээ.

Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2019 оны 1-15 дугаарт товъёог үйлдэж санд бүртгэлээ

Зэвсэг-2019 арга хэмжээнийд зарцуулагдах зардал гаргах тухай Тушаалын төсөл боловсруулж эрх бүхий албан тушаалтнуудаар тойруулж виз авч албажууллаа.

“Од” цогцолбор сургуулийн захирал Х.Баярбилэг, Шарын гол сумын 6-р сургуулийн захирал Н.Сүхбаатар, Байгаль орчин аялал жуулчлалын дарга С.Ганзоригын ХАСХОМ-г хүлээн авч шалгаж холбогдох засварыг хийлгэж баталгаажууллаа.

Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 2-р улирлын нийт 76 тушаалын хууль зүйн үндэслэлийг хяналаа.

Дархан сумын 8 дугаар багийн иргэн Д.Наранчимэг, Хонгор сумын салхит багийн иргэн Д.Бат-Эрдэнэ нарт Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хуулийн талаар анхан шатны хууль зүйн зөвлөгөө өглөө.

Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол, мэдээлэл хариуцсан ажилтнуудын судалгааг 33 байгууллагаас гаргуулан авч нэгтгэн хүргүүлээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Томоохон аж ахуйн нэгж их дээд сургуульд сургалт зохион байгуулах ажлын хэсгийг хуралдуулах, сургалтын хуваарь, ажлын зохион байгуулалт хийх, сургалтын хүрээ, үргэлжлэх цаг хугацааг тогтох хариуцах эзэнийг тогтоож, сургалт явуулах хуваарийг гаргалаа. 22 томоохон аж ахуйн нэгж, их дээд сургууль, полтехникийн коллеж, ерөнхий боловсролын сургуулийн 1466 ажилтан албан хаагч, сурагч, оюутнуудад ГХУС тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Авлига, түүний хор хөнөөл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар сургалт зохион байгууллаа.

E-khutuch.mn цахим сайтад байршуулах мэдээллүүдийн талаарх дэлгэрэнгүй маягыг албан тоотын хамт Дархан, Шарын гол, Орхон, Хонгор сумын Засаг даргад хүргүүлээ.

Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь төлөөлөгчтэй хамтран зохион байгуулах “Хүүхдийн эрх”, “Өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, “Өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд”, сэдвээр зохион байгуулах сургалтын төлөвлөгөө боловсрууллаа.

Анхан шатны шүүхийн Тамгын хэлтсийн 12 албан хаагчдад төрийн албаны тухай хуульд нийцүүлэн шинээр баталсан 6 журмаар сургалт зохион байгууллаа.

Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс бэлтгэн ирүүлсэн богино хэмжээний 6 кино, сурталчилгааны 15 шторк, АТГ-аас

бэлтгэсэн ирүүлсэн 4 төрлийн шторкыг орон нутгийн телевиз, Залуучууд театрын дэлгэцээр гаргалаа.

4.Нийгмийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл, урлагийн чиглэлээр:

Уралдаан тэмцээн:

Хөдөөгийн багш нарын спортын ХҮИ наадам 10 дугаар сарын 09-13-ны хооронд Хөвсгөл аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Манай аймгаас спортын таван төрлөөр 45 багш тамирчдын бүрэлдэхүүнтэй оролцож. Сагсан бөмбөгийн төрлөөр эрэгтэй баг алтан медал, ганцаарчилсан төрөлд теннис хүрэл медал хүртэж, 16 аймгийн баг тамирчдаас багийн дүнгээр 2-р байр эзэлсэн амжилт үзүүллээ.

Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат Батлан хамгаалах яамны сайдтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дагуу ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг эх оронч хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдар сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх, Монгол цэргийн залгамж халааг бэлтгэх зорилготой “Эх орон мандах ирээдүй” тэмцээн Дархан хотод 2 өдөр болж аваргуудаа тодрууллаа.

Сургалт үйл ажиллагаа

2019-2020 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Индекс-2” шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд Од цогцолбор сургууль дээр даалгаврын сангийн багийн ахлагч нартай сангийн сайжруулалт, баяжилт дээр хамтран ажиллаж шинэ суралцахуйн удирдамжийн дагуу VI-XII анги тус бүр дээр 420-670 даалгавартай сан бүрдүүлсэн ба мэргэжлийн багш нарын группт байршуулж багш, сурагчдад хүргэлээ.

Энэ хичээлийн жилд математикийн хичээлийг сонгон суралцаж элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 12-р ангийн сурагчдын судалгааг гарган төлөвлөгөөний дагуу эхний сорил шалгалтыг 10-р сарын 19-ны өдөр Од цогцолбор, Шинэ алхам, 9-р сургуулиуд зохион байгуулж явууллаа. Аймгийн хэмжээнд нийт ЕБ-ын 21 сургуулийн 680 /62,6%/ сурагч хамрагдлаа. Сорилын дүнд анализ хийж цаашид анхаарах сэдэв, даалгавруудыг гүйцэтгэхэд анхаарч ажиллаж байна.

Аймгийн БСУГ, БМДИ-тэй хамтран Иргэний ёс зүй сургалт 3 хоног зохион байгуулж 88 багш хамрагдлаа.

- Хөвсгөл аймагт сургалтын менежерүүдийн арга зүйн сургалт боллоо.
- Улаанбаатар хотод СӨБ-ын сургалт болов.
- Улаанбаатар хотод боловсролын үнэлгээний сургалт боллоо.
- Либераль эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ-ийн Авилгагүй Нийгмийн төлөөлөл иргэдийн оролцоо сургалтад мэдээлэл хийв.

СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРЭЭНД:

Хүүхдийн номын ордон:

- 93 уншигчийн 881 ирцэд 1133 ном олгосон.
- “Номтой өдөр” явуулын номын сангийн үйлчилгээг 2019 оны 10-р сарын 16-17 -ны өдрүүдэд 18-р сургууль дээр зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд шинэ уншигч бүртгэн, ном уншлага зохион байгуулж мөн ном унших арга барил хэрхэн суралцах, номын тэмдэглэл хэрхэн хөтлөх талаар зөвлөмж өгч, танин мэдэхүйн уралдаан зохион байгуулав
- ✓ Шинээр уншигч – 24
- ✓ Ирэгсэд – 258
- ✓ Ном олголт – 479
- Нийт 300 гаруй багш сурагчид, эцэг эхийн төлөөлөл хамрагдсан .

Төв номын сан:

- 72 уншигчийн 633 ирцэд 1026 ном олгосон.

Залуучууд театр:

Нийт 10 удаагийн тоглолт, арга хэмжээг их зааланд зохион байгуулж 3318 үзэгчдэд толилуулсан.

Музей:

- Энэ долоо хоногт насанд хүрэгчид 50, хүүхэд 156, нийт 206 үзэгч олон нийтэд үйлчилсэн байна.
- 10 дугаар сарын 15-ны өдөр "Дэлхийн цагаан таягтны өдөр" буюу харааны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тохиодуулан Дархан-Уул аймагт ажиллаж амьдарч байгаа харааны бэрхшээлтэй 15 иргэнд нийгмийн хариуцлагын хүрээнд үнэ төлбөргүй үйлчиллээ.
- МГЗНХолбооны Дархан салбарын гэрэл зурагчид болон Аймгийн Төв музейн хамт олны хамтран Дархан хот байгуулагдсаны 58 жилийн ойн баярт зориулсан Ахмад, залуу гэрэл зурагчдын "ӨНӨӨДРИЙН ДАРХАН" гэрэл зургийн үзэсгэлэн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Залуучууд Театрт болно. Тус гэрэл зургийн үзэсгэлэнд 60 гаруй өнгөт зургийг олон нийтэд үзүүлж сонирхууллаа.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР